



I-V/2022


Тархаасан: 2022 оны 7 дугаар сарын 18



## Төлбөрийн тэнцэл 2022 оны 5 дугаар сард 105.2 сая америк долларын алдагдалтай гарлаа

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2022 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.8 тэрбум америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 1.0 (2.4 дахин) тэрбум америк доллароор өсжээ. Уг өсөлтөд барааны худалдааны алдагдал өмнөх оны мөн үеэс 706.5 сая америк доллароор, анхдагч орлогын алдагдал 232.4 сая америк доллароор өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин урсгал дансны алдагдал 2022 оны 5 дугаар сард өмнөх сараас 193.2 сая америк доллароор буурч, 238.5 сая америк доллар болжээ.

ЗУРАГ 1. УРСГАЛ ДАНС, сараар, сая америк доллароор



Үйлчилгээний худалдааны орлого 2022 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 319.7 сая америк доллар, зарлага 1.0 тэрбум америк доллар болж, орлого өмнөх оны мөн үеэс 16.2 сая америк доллароор, зарлага 144.3 сая америк доллароор тус тус өссөн байна. Үйлчилгээний худалдааны алдагдал 2022 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 128.1 сая америк доллароор өсөж, 728.9 сая америк доллар болжээ.

ХҮСНЭГТ 1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, салбараар, сая америк доллароор

Үзүүлэлт	2021		2022*	
	V	I-V	V	I-V
<b>Үйлчилгээ</b>	<b>- 100.6</b>	<b>- 600.8</b>	<b>- 121.4</b>	<b>- 728.9</b>
Кредит	53.7	303.6	86.7	319.7
Дебит	154.3	904.4	208.1	1 048.6
Тээвэр	- 17.2	- 70.9	- 42.3	- 134.6
Кредит	38.2	210.2	57.5	206.5
Дебит	55.5	281.0	99.8	341.1
Аялал	- 42.6	- 339.0	- 38.3	- 335.6
Кредит	1.4	5.9	11.5	26.3
Дебит	44.0	344.8	49.8	361.9
Бусад үйлчилгээ	- 40.7	- 191.0	- 40.8	- 258.8
Кредит	14.1	87.5	17.7	86.9
Дебит	54.8	278.5	58.6	345.6

Хөрөнгийн данс 2022 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 64.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 25.7 сая америк доллароор өсжээ. Мөн 5 дугаар сард 19.6 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 3.4 сая америк доллароор өссөн байна.

Санхүүгийн дансны тэнцэл 2022 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 764.0 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 55.5 сая америк доллароор өсжээ. Харин 5 дугаар сард 159.9 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 149.5 сая америк доллароор буурсан байна.

ХҮСНЭГТ 2. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, сая америк доллароор

Үзүүлэлт	2021		2022*		Төлбөрийн тэнцэл 2021 оны эхний 5 сард 231.6 сая америк долларын ашигтай байсан бол 2022 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум америк доллароор буурч, 1.0 тэрбум америк долларын алдагдалтай болсон байна. Төлбөрийн тэнцэл 2022 оны 5 дугаар сард 105.2 сая америк долларын алдагдалтай гарчээ.
	V	I-V	V	I-V	
Урсгал данс	- 157.6	- 724.6	- 238.6	- 1 768.5	
Хөрөнгийн данс	8.4	38.8	19.6	64.5	
Санхүүгийн данс	- 203.7	- 708.6	- 160.0	- 764.0	
Алдаа болон орхигдуулга	- 67.9	208.8	- 46.2	- 108.1	
Нөөц хөрөнгө	- 13.4	231.6	- 108.4	- 1 048.0	

## Ойлголт, тодорхойлолт

**Төлбөрийн тэнцэл:** Тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалын орлого, зарлагын гүйлгээг нэгтгэсэн статистикийн тайлан бөгөөд дараах 3 бүлгээр нэгтгэн боловсруулдаг.

**Урсгал данс:** Эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээ, анхдагч орлого, орлогын дахин хуваарилалтын урсгалыг харуулах бөгөөд бараа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлгийн нийлбэрээс бүрдэнэ.

**Хөрөнгийн данс:** Хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

**Санхүүгийн данс:** Монгол Улсаас бусад гадаад улсад хийсэн хөрөнгө оруулалт/актив/, бусад улсаас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалтын/пассив/ гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна. Санхүүгийн дансанд активын өсөлт пассивынхаас илүү, активын бууралт пассивынхаас бага эсвэл актив өсөж, пассив буурсан үед "+" буюу алдагдалтайг, эсрэгээр пассивын өсөлт активынхаас илүү, активын бууралт пассивынхаас илүү эсвэл актив буурч, пассив өссөн үед "-" буюу ашигтайг илэрхийлнэ.

**Цэвэр нөөц:** Гадаад валютын улсын нөөцийг Олон Улсын Валютын Сангийн зээлийн үлдэгдэл болон богино хугацаат гадаад пассивын дүнгээр цэвэрлэж тооцсон нөөцийг ойлгоно.

**Цууд хөрөнгө оруулалт:** Харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар, харьяа нэгжийг байгуулах үйл ажиллагааг ойлгоно.



### Эх үүсвэр:

Монголбанк

### Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

### Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 8 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Н.Адъяадорж  
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212